

Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт хариуцсан шинжээч, Гунгаа Сүнжидмаа

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
1	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын нөхцөл байдалд тандан судалгаа хийж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах арга хэмжээг удирдлага зохицуулалтаар хангана.	Судалгааны тайлан - авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Хилийн застав, асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхэд, эрх нь хязгаарлагдсан хүүхэд, сүм хийдэд шавилан сууж буй хүүхдийн боловсролд хамрагдалтын нөхцөл байдалд тандан судалгаа хийсэн байна.	БШУСайдын 2024 оны А/186 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ерөнхий боловсролд хамрагдалтын нөхцөл байдлыг тандан судлах" судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.Асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхэд, эрх нь хязгаарлагдсан хүүхэд, сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн талаарх одоогийн бодлого, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, тулгамдаж буй саад бэрхшээлийг тодорхойлох, өнөөгийн боловсролын бодлого, хэрэгжилтийг нарийвчлан үнэлэх, цаашид авах арга хэмжээний талаар бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Судалгаанд аймаг, нийслэлд үйл ажиллагаа	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					явуулж буй 20 асрамж халамжийн төв, хөдөлмөрийн төрөлжсөн ерөнхий боловсролын 110 дугаар дунд сургууль, нийслэлийн ерөнхий боловсролын 112 дугаар сургууль хамрагдлаа. Судалгааны дүгнэлтийг үндэслэн зөвлөмж боловсруулж ажиллалаа. Хавсралт: 3 файл		
2	Цэцэрлэг, сургуулийн багш нарыг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад үе шаттай хамруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах.	Сургалтад хамрагдсан багшийн тоо	-	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 150 багшийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах ара зүйн сургалтад хамруулсан байна. 500 багшийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулсан байна. Тэгш хамран сургах боловсролын багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдсан байна.	- Боловсролын сайдын 2024 оны А/118 дугаар тушаалаар батлагдсан "Багш, тусгай хэрэгцээт боловсрол" мэргэжлээр хөрвөх тэтгэлэгт сургалтад хамрагдах ерөнхий боловсролын сургуулийн багш нарт тэтгэлэгт хөтөлбөрийн батламжийг гардуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. - Боловсролын сайдын 2024 оны А/86 дугаар тушаалаар батлагдсан "Монгол дохионы хэлний анхан шатны мэдлэг, чадвар олгох" сургалтыг Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран зохион байгууллаа. Боловсролын дэлхийн түншлэл" (GPE) олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" (EQUAL) төслийн хүрээнд Архангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймаг, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 18 багшийг "Монгол дохионы хэлний анхан шатны мэдлэг чадвар олгох	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сургалт"-д хамруулж, батламж олголоо. -Боловсролын сайдын 2024 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт тэгш хамруулах боловсролын цахим платформ бий болгох" төслийн хүрээнд "Тэгш хамран сургах боловсрол"-ын арга зүйн сургалтад 21 аймг, 9 дүүргийн тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтэн, 30 багш, 60 хүнийг сургагч багшаар бэлтгэлээ.		
					Хавсралт: 3 файл		
1.2. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох ажлыг удирдлага зохицуулалтаар хангах							
3	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлагаар хангах	Шинэчлэн боловсруулсан үнэлгээний аргачлал	Үнэлгээний аргачлал	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулсан байна.	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлагаар хангах, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний арга зүйд тохируулга хийх санал боловсруулж ажиллалаа. СӨБ, ЕБС, МБТБ-ын багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх ажлын хүрээнд тусгай сургууль, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалын санал боловсруулан тусгав.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.1. Тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх богино хугацааны төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрхзүйн баримт бичгийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангах							

4	Тусгай хэрэгцээт боловсролын багшийг хөрвөх сургалтаар бэлтгэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах.	Багшийн гурван тулгуурт хөгжлийн бодлого	МУБИС-ийн багш, тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөр	Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хөрвөх сургалтыг эхлүүлсэн байна.	Боловсролын сайдын 2024 оны А/118 дугаар тушаалаар Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн “Тэгш хамран сургах боловсрол” бүрэлдэхүүний хүрээнд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, МУБИС болон төслийн баг хамтран тэгш хамран сургах боловсролын чиглэлээр баримталж буй бодлого шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилтийг танилцуулах, тусгай хэрэгцээт боловсролын талаар олон нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулсан. Сургалтын 90,0 гаруй сая төгрөгний тэтгэлгийг Улаанбаатар хот, орон нутгийн ерөнхий боловсролын 18 сургуулиас тус бүр 1 буюу нийт 18 багшид олгон, Монгол Улсын Боловсролын Их Сургуульд “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлээр 1 жилийн хөрвөх сургалтад хамруулж байгаа юм. Мөн МУБИС-ийн “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлийн хөрвүүлэх сургалтад хамрагдах Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт тэтгэлэгт хөтөлбөрийн батламжийг гардуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Хавсралт: 3 файл	9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Бага боловсролын	Бага	-	Бага боловсролын	Монгол Улсын Засгийн газрын	9-р сар,	Өөрийн

казак, тува хэлний сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах	боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.		казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.	хуралдааны 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал 2024-2036”-ийг үндэслэн бага боловсролын тува хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Энэхүү сургалтын хөтөлбөрт тува хэлний судлагдахуунаар сурагчийн эзэмших ерөнхий болон суурь чадамж, тува хэлний чадвар (сонсох, ярих, унших, бичих)-ууд, агуулгын залгамж холбоо (ай, дэд ай), тува хэлний сургалтын арга зүй, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээ, суралцахуйн удирдамж гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал болон багшлахуй, суралцахуйн онол, зарчимд нийцүүлэн тодорхойлов. Энэ удаа багш нартаа бага боловсролын тува хэлний шинэчилсэн сургалтын хөтөлбөр, дасгал ажлын дэвтэрийг Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 2дугаар сургуульд, Казах хэлний сургалтын хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын дэвтрийг Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургуульд, Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургуульд тус тус туршиж байна. Хавсралт: 2 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	--	--	---	------------------------------	--

3.2. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах

6	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн https://meds.igovernment.mn/law/ цахим системд хугацаанд нь ТЗУГ-т хүргүүлсэн.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Хэрэгжилтийг тайлагнасан.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

	тайлагнах						Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Боловсролын сайдын 2024 оны А/202 дугаартай тушаалаар батлагдсан Тэгш хамран сургах боловсролыг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод сурталчлан таниулсан. Хавсралт: 1 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Тэгш хамруулах боловсролын чиглэлээрх мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	Монгол Улсын болон олон улсын сайн туршлага судалж, түгээн дэлгэрүүлэх	-	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр сайн туршлага судалж, түгээн дэлгэрүүлсэн байна.	ГБХНХЯ-аас зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын тайлан боловсруулахад анхаарах асуудлууд" сэдэвт сургалтад хамрагдсан. Адина тэгш боломж төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан тэгш хамруулах боловсролын цахим сургалтын платформ бий болгох төсөл"-ийн хүрээнд цахим сургалтын платформд байршуулах агуулгыг зөвлөх багууд хөдөлгөөний, хэл ярианы, сонсголын, оюуны, харааны, суралцахуйн бэрхшээлтэй, дауны хам шинжтэй, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйн 9 модулийг боловсруулсан. Мөн "Тэгш хамруулах боловсролын сургагч багш бэлтгэх" онол, дадлага хосолсон арга зүйн сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж Боловсролын ерөнхий газрын даргын	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

					01/4999 тоот албан бичгээр 21 аймгийн Боловсролын газар, 9 дүүргийн Боловсролын хэлтсүүдэд хүргүүлэн сургалтын бэлтгэл ажлыг хангасан. Сургалт 2024 оны 12 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Боловсролын газар, хэлтсүүдийн тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтнүүд болон зорилтот 30 сургуулийн удирдлага, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарын төлөөлөл нийт 60 албан хаагчид хамрагдлаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/31 дүгээр тушаалын дагуу Олон Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг угтсан аяныг зохион байгуулах ажлын хэсэгт хамтран ажилласан. Тус ажлын хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний чуулган, "Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж-2024" эрдэм шинжилгээний бага хурал хурал, Ability expo-2024 зэрэг арга хэмжээг хамтран зохион байгуулсан. Хавсралт: 2 файл		
2	Эрх зүйн боловсролоо	Байгууллагын албан хаагчдын	-	Төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг	Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох хууль, тогтоомжийг	9-р сар, 10-р сар,	Өөрийн

	дээшлүүлэх	мэдлэг, чадварыг дээшлүүлэх зохион байгуулалттай сургалт хөгжлийн хөтөлбөрт тогтмол хамрагдах		хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хуулийг чанд мөрдөж, авилга, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	судалсан. Байгууллагаас 7 хоног бүр зохион байгуулагдаж буй мэдээллийг цагт хамрагдсан. Төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хуулийг чанд мөрдөж, авилга, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан.	11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
--	------------	---	--	---	--	--------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт хариуцсан шинжээч, Гунгаа Сүнжидмаа
/...../ Огноо: